

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Г.ХОСБАЯР

ДХИС-ийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хууль зүйн магистр, хошууч

Товч агуулга: Өгүүлэлд хорих байгууллагын аюулгүй байдал, түүнийг зохион байгуулах, хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар судлаачийн байр суурийг илэрхийлсэн.

Түлхүүр үгс: Хорих байгууллагын аюулгүй байдал, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хорих ял эдлүүлэх ажиллагаа, анхаарах асуудал.

Оршил

Хууль зүйн шинжлэх ухаан тэр тусмаа гэм буруутай этгээдийн хийсэн үйлдэлд нь хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий этгээдээс шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох арга замыг тодорхойлохоор эрдэмтэн, судлаачид өнөөг хүртэл өөр өөрсдийн үзэл бодол, чиг хандлагыг дэвшүүлсээр байна. Ялангуяа эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, түүний хэрэгжилтийг хангахад учирч буй саад бэрхшээл, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохын тулд судалгаа, шинжилгээ явуулах, тэдгээрийн үр дүнг практикт зүй зохистойгоор ашиглах нь онолын болон практикийн ач холбогдолтой.

Манай улсын Эрүүгийн хуулинд заасан гэмт хэргийн нийгмийн аюулын шинж, гэм хорын хэмжээгээр шалгуур болгон хөнгөн болон хүнд гэмт хэргүүдэд эрүүгийн хариуцлага ногдуулдаг. Тиймээс тэдгээр хоригдол, хоригдогч нарыг хорих байгууллагад шилжүүлж нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарлаж, нийгэмшүүлэх нэгдсэн арга хэмжээг авдаг болно.

Шүүхийн шийтгэх тогтоолоор эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тухайн хоригдогч,

хоригдлын хувийн байдал, субъектив шинж нь хорих байгууллагын дотоод нөхцөл байдлыг хүндрүүлэх шууд болон шууд бус эрсдэлт хүчин зүйлсийг агуулж байдаг. Тухайлбал, хоригдогч, хоригдогч хорих байгууллагаас оргох, албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчид халдах, өөрийн болон бусдын амь бие, эрүүл мэндэд хорио хохирол учруулах, амиа хорлох, амиа хорлохыг завдах, хорих ангид үймээн дэгдээх зэрэг гэмт үйлдлүүдийг хийдэг байна.

Өнөөдрийн байдлаар хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, харуул хамгаалалтаар хангах үйл ажиллагааны талаар хийсэн судалгаа, эрдмийн бүтээл төдийлөн хангалттай бус байгаа нь цаашдаа энэ салбарын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, чиг хандлагыг тодорхойлох үндэслэл болж байна.

Үндсэн хэсэг

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тухай асуудлыг судлахын тулд юуны өмнө аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт, түүний мөн чанар, ач холбогдлыг авч үзэх нь зүйтэй.

Биологийн амьд биетийн хөгжлийн мөн чанар нь үндсэндээ тэдгээрийн аюулгүй байдлаа хангах

гэсэн тэмцлийн үр дүн юм. Ямар ч амьтадын амьд үлдэхийн төлөөх төрөлхийн зөн билэг нь аюулгүй байдлаа хангах үйлдэл хийхэд хүргэдэг. Энэхүү аюулгүй байдлаа хангах гэсэн үйлдэл нь хувьсал хөгжилд хөтөлдөг байна. Хүн ч гэсэн ялгаагүй биологийн амьд биет болохын хувьд түүний аюулгүй байдал нь оршин тогтнох үндэс нь мөн.

Харин харьцангуй аюулгүй байдал гэж хүн төрөлхтөн ухаарч, илрүүлж чадах боломжтой аюул занал бөгөөд уг аюул занал үүсэн бий болох нөхцөлийг арилгаж, түгшүүр айдасгүйгээр оршин тогтнох боломжийг бүрдүүлж болох юм гэж энэ чиглэлээр судалгаа хийдэг судлаачид тайлбарладаг.

Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг Оросын Холбооны Улсын эрдэмтэн В.И.Спиридонов "Аюулгүй байдал гэдэг нэр томъёо нь судалгааны бүтээлүүдэд ихээхэн олон утгатай бөгөөд одоо хүртэл энэ ойлголтонд оновчтой чамбай тодорхойлолт өгч чадахгүй байна" гэж тодорхойлсон.

Мөн зарим тохиолдолд аюулгүй байдлыг зорилго гэж үзэж байхад, нөгөө тохиолдолд үзэл баримтлал, харин гурав дахь нь шинжлэх ухааны хөтөлбөр, эсвэл салбар шинжлэх ухаан гэж үзэж байна.

Одоо хүртэл аюулгүй байдлын нэгдмэл үзэл баримтлал байхгүй бөгөөд "бие хүний аюулгүй байдал", "үндэсний аюулгүй байдал", "олон улсын аюулгүй байдал", "даяаршлын аюулгүй байдал" зэрэг ойлголтууд нь тэс өөр өөр асуудлуудтай хутгалдаж, философи, түүхийн хавсарга төдий явж байна"¹ гэж дүгнэн бичсэн байдаг. Аюулгүй байдлыг нийгмийн үзэгдэл талаас нь тодорхойлвол улс үндэстэн, нийгмийн тодорхой бүлэг, хувь хүний

оршин тогтнох язгуур эрх, ашиг, сонирхол баталгаатай хангагдсан байдал гэж ойлгож болно. Язгуур эрх ашиг хэмээх ойлголтыг тодорхойлбол тухайн улс, үндэстэн, хүмүүсийн олонлог, нийгмийн бүлгүүдийн оршин тогтнохуйн үндэс, хүний эрх, эрх чөлөөг илэрхийлсэн ойлголт юм. Аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа гэх ойлголтууд нь хоорондоо харилцан хамаарал бүхий ялгаатай ойлголт юм. Аливаа юмс үзэгдэл, объектыг хамгаалах явдал, түүний мөн чанар нь дараахь агуулгаар илэрхийлэгддэг. Үүнд:

1. Тодорхой объектыг гадны сөрөг хүчин зүйлсээс хориглон хамгаалах;

2. Хамгаалалтад буй объект өөрөө хүрээлэн буй орчиндоо аюул учруулахаас сэргийлэн хамгаалах;

3. Тухайн объектыг ямар ч тохиолдолд хаацайлж, туушдаа хамгаалах ёстой² гэж Миддлексийн их сургуулийн профессор Петер Хоф аюулгүй байдал судлалын онолын хүрээнд тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг хуулийн хүрээнд гүйцэтгэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан цээрлэлийг эдлүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан эрхийг нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, хоригдол, хоригдогчийг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Эрүүгийн хариуцлагын зорилго, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь салшгүй холбоотой бөгөөд хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглүүлэгч нь эрүүгийн хариуцлага байдаг бол уг зорилгыг

¹ <https://www.routledge.com/Critical-Security-Studies-Concepts-And-Strategies/Krause-Williams/p/book/9781857287332>

² <https://www.routledge.com/International-Security-Studies-Theory-and-Practice/Hough-Moran-Pilbeam-Stokes/p/book/9780367109868>

хангах арга хэрэгсэл нь хорих ял эдлүүлэх ажиллагаа байдаг.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт, төрийн үйл ажиллагааны механизм бөгөөд шүүхийн шийдвэрээр хорих ял шийтгэгдсэн этгээдийн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт хийж, байнгын хяналт, харуул хамгаалалтын дор, олон нийтээс тусгаарлаж буй төрийн албадлагын онцгой арга хэмжээ гэж тодорхойлж болно.

Хорих байгууллагын харуул хамгаалалт нь ялтныг олон нийтээс тусгаарлан тэднээс дахин давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, үйлдсэн хэргийг илрүүлэх, таслан зогсоох, холбогдох хууль, хорих ангийн дотоод журам, цагийн хуваарийг чанд мөрдүүлэх, хорих анги болон ялтны аюулгүй байдлыг хангахад ¹ чиглэгдэнэ гэж зарим судлаачид үзжээ.

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зохион байгуулалтыг дараах байдлаар ангилан авч үзэж болно. Энэ нь:

1. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах нь:

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тухай цөөхөн тооны судалгааны бүтээлд түүнийг тодорхойлсон байдлыг авч үзвэл: "Хорих ангийн аюулгүй байдал гэдэг нь хорих анги, баривчлах, цагдан хорих байрны хэвийн үл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, ноцтой хор уршиг учруулж болзошгүй гадаад дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс хамгаалах зорилгоор эрх, үүрэг бүхий субъектуудээс хэрэгжүүлж буй тасралтгүй шинж чанар бүхий арга хэмжээний цогц

оновчтой бүтэц бүрдэх явдал" ² хэмээн тодорхойлжээ.

Дээрх тодорхойлолтоос үзвэл хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь дараах үндсэн шинжийг агуулж байна. Үүнд:

1. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зорилго, зорилтыг тодорхойлох;

2. Хорих ангийн аюулгүй байдлыг хангахад нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөлөл;

3. Тусгай эрх үүрэг бүхий субъектүүд /төрийн тусгай албан хаагчид/ гэмт үйлдлээс хамгаалах үүрэг хүлээсэн;

4. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тасралтгүй, үйл ажиллагаа явуулах бүтэцтэй байх зэрэг болно.

Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь хоорондоо нягт уялдаа холбоо бүхий цогц арга хэмжээ байдаг тул уг арга хэмжээг зохион байгуулахдаа дараахь үндсэн зарчмыг баримтлах шаардлагатай. Үүнд:

- Хорих ангийн аюулгүй байдлыг хангах зорилго, зорилтоо тодорхойлж түүнд нийцсэн үйл ажиллагааг явуулах;

- Аюулгүй байдал, хор уршиг учруулж болзошгүй аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тэргүүлэх шинж чанартайгаар хэрэгжүүлэх;

- Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээ шуурхай тасралт чанартай байх;

- Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шинжлэх ухаан, техник, технологи, инновацийн бүтээгдэхүүн, хэрэгслийг нэвтрүүлэх;

- Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тогтолцооны хүрээнд явагдаж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаа, хүч хэрэгслүүд нь

¹ Б.Нямгомбо, Ч.Хүрэлбаатар нар. Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаа. Уб хот., 2013 он. 8 дахь тал.

² Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. Уб хот., 2017 он. 23 дахь тал

хоорондоо нягт уялдаа холбоотой байх;

- Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд нь гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалан уян хатан байх зэрэг болно.

Мөн олон улсын түвшинд түгээмэл хэрэглэгдэж буй хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээ нь дараах тогтолцооны хэлбэрийг агуулж байна. Үүнд:

1. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ
2. Биечилсэн болон техникийн хяналт, хамгаалалтын үйл ажиллагаа
3. Хиймэл оюун
4. Гүйцэтгэх ажил
5. Нийгэм, сэтгэл зүйн арга хэмжээ зэрэг ажиллагаанууд багтана.

Эдгээр аюулгүй байдлыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг харилцан уялдаа холбоотойгоор хэрэглэх нь хоригдогч, ялтануудын хорих байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, ноцтой хор уршиг бүхий үр дагавар үүсгэхээс урьдчилан сэргийлж чадна хэмээн үзэн, дүгнэдэг байна.

2. Хорих байгууллагын аюулгүй байдлыг харуул хамгаалалтаар хангах нь:

Хорих байгууллага нь хорих анги, баривчлах, цагдан хорих байрыг өөртөө агуулсан харьцангуй өргөн хүрээний ойлголт бөгөөд тэдгээрийг тусгай субъектийн үйл ажиллагааны хүрээнд харуул хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нэн тэргүүний шаардлагатай байдаг.

Монгол улсын Эрүүгийн хуульд заасан ялын төрлүүдээс хорих ял нь шүүхийн практикт өргөн хэрэглэгдэж ирсэн бөгөөд цаашид хорих ял эдлүүлэх дэглэмийн ойлголт, шаардлагын талаар судлах хэрэгцээ өссөн хэвээр байна.

Учир нь тухайн хорих ангийн дэглэм, зэрэглэлээс хамааруулан тогтоох харуул хамгаалалтын хэлбэрийг харилцан өөр түвшинд зохион байгуулдаг. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хугацаатай хорих ялыг нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно”¹ хэмээн заасан нь хорих ангийн дэглэмийн хэлбэрийг ангилан заасан явдал юм.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс зэрэг улс орнуудын жишээнээс харахад ял эдлүүлэх дэглэмийн төрлийг шүүх бус тухайн ял эдлүүлэх байгууллага өөрийн “нээлттэй” “хаалттай” алинд нь хүлээн авахыг зохих шалгуураар үндэслэн шийдвэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл ямар төрлийн дэглэмтэй хорих анги байгаагаас нь хамааруулан харгалзагч, албан хаагчдын орон тоо, хоригдогч, хоригдлуудад тавих хяналт, харуул хамгаалалтын бүсийг тодорхойлох боломжтой юм.

Цаашид мэргэшсэн алба хаагч, удирдлагын тоог нэмэгдүүлэх нь хорих байгууллагын харуул хамгаалалтад дэвшил болон нөлөөлөхүйц ихээхэн ач холбогдолтой юм.

Дүгнэлт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд зөвхөн хорих ангийн харуул хамгаалалтын бүсийн нөхцөлийг тодорхойлон заасан нь ихээхэн дутагдалтай гэж үзэж байна. Тухайлбал, “гадна хориотой бүс, хамгаалалтын хашаа, дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, цахилгаан хүчдэлийн шугам, дүрс

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ хот., 2017 он. №7

бичлэгийн хяналт бүхий зурвас” хэмээн заасан байгаа нь орчин үеийн харуул хамгаалалтын техник, технологиос хоцрогдсон, харуул хамгаалалтын хэлбэрийг техникийн болон биечилсэн хамгаалалтыг алба хаагч нарын гүйцэтгэх үүрэг зэргийн нарийн тодорхойлж зааглаагүй хэт ерөнхий шинж бүхий зохицуулалтай хэм хэмжээний акт болсон байна гэж бидний зүгээс үзэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, ялангуяа хорих байгууллага нь үндэсний аюулгүй байдал, түүний дотор дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдлыг ханахад чухал үүрэгтэй.

Тухайлбал, Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн цагдан хорих шийдвэрийг биелүүлэх, хорих ялыг биечлэн эдлүүлэх, тэднийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас хорих байгууллагад хоригдогсод, тэнд ажилагсадын аюулгүй байдлыг хангах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг нь үндэсний аюулгүй байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хорих байгууллага нийгмийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн гүйцэтгэж буй байдал, явуулж байгаа үйл ажиллагаанаас үндэсний аюулгүй байдал хангагдах эсэх нь тодорхой хэмжээгээр шалтгаалдаг.

Өөрөөр хэлбэл хорих байгууллагын ажилтны ажлын гүйцэтгэлийн үр дүнгээс байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлт, цаашлаад үндэсний аюулгүй байдал бүрэн хангагдах эсэх нь шалтгаална.

Иймд хорих байгууллагын албан хаагчид нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хэрхэн хангах талаарх мэдлэгийг эзэмшсэн байхаас гадна түүнийг бодит нөхцөлд, амьдралд хэрэгжүүлж чаддаг байх шаардлагатай.

Дээрх бүгдээс дүгнэн үзвэл хорих байгууллагын аюулгүй байдлыг харуул хамгаалалтын хэлбэрээр

ханган, олон улсын жишгээр зохион байгуулах нь ач холбогдолтой юм.

Санал

Дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Олон улсын хүрээнд хорих байгууллагын харуул хамгаалалтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар судалгаа явуулж, дэвшилтэд хэм хэмжээ, арга туршлагыг практикт ашиглах арга хэлбэрийг тодорхойлох, нэвтрүүлэх;

2. Хорих байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актууд тэдгээрийн хэрэгжилтийг судлан эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

3. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах техникийн арга хэмжээнд хиймэл оюуныг нэвтрүүлэх;

4. Харуул хамгаалалтын арга хэмжээнд шаардлагатай цогц үйл ажиллагаануудыг боловсруулан хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг цаашдаа хэрэгжүүлэх боломжтой зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он.

- Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999 он.

- Эрүүгийн хууль, 2015 он.

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоол.

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” тогтоол

- Хорих ангийн харуул хамгаалалтын журам, “Сүлд инфо”, УБ хот., 2017 он.

- Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам, “Сүлд инфо”, УБ хот., 2017 он.

- А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ хот., 2008 он.

- Ц.Очгэрэл. Хорих байгууллагын аюулгүй байдал. УБ хот., 2017 он. 23 дахь тал

- Хорих байгууллагын үйл ажиллагаа, нийгэмшүүлэх, олон нийтэд суурилсан засан хүмүүжүүлэх ял эдэлж бй хоригдогсдод хяналт тавих зэрэг үйл ажиллагаанд орчин үеийн техник технологийг ашиглах нь.

-

Ази Номхон Далайн бүс нутгийн хорих байгууллагын удирдах ажилтнуудын 39 дүгээр бага хурал. 2019 он.

- <https://www.routledge.com/Critical-Security-Studies-Concepts-And-Strategies/Krause-Williams/p/book/9781857287332>

- <https://www.routledge.com/International-Security-Studies-Theory-and-Practice/Hough-Moran-Pilbeam-Stokes/p/book/9780367109868>